

## Нэрт археологич Загдын Батсайханы 70 насны ойд

Энэ онд археологич доктор, профессор З.Батсайханы төрсний 70 жилийн ой болж байна. Хэрээд овогт З.Батсайхан бол Монголын эртний судлалын шинэ үеийн эхлэлийг тавилцсан археологич эрдэмтний нэг бөгөөд МУИС-ийн Археологийн хөтөлбөрийг хөгжүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан профессор багш билээ.

Хэрээд овогт З.Батсайхан 1954 онд Улаанбаатар хотод сэхээтний гэр бүлд мэндэлжээ. 1972 онд Улаанбаатар хотын 10 жилийн 11-р дунд сургууль, 1981 онд МУИС-ийн Нийгмийн Ухааны Факультетийн Түүхийн салбарыг түүхч, түүхийн багш мэргэжил эзэмшин төгсгөсөн. 1987-1997 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, 1997-2020 онд МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн Антропологи, Археологийн тэнхимд ахлах багш, дэд профессор, зөвлөх профессороор ажилласан. Тэрбээр, 1993 онд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол дахь салбарын дэргэдэх тусгай зориулалтын англи хэлний курс, 1991 онд Чех улсын ШУА-ийн Археологийн хүрээлэнд, 2000, 2004 онд Францын Тулузийн Их Сургуульд эрдэм шинжилгээний томиллолгоор явж мэргэжил дээшлүүлжээ.

З. Батсайхан нь 1988-1990 онд Монгол-Зөвлөлтийн түүх, соёлын хамтарсан экспедицийн чулуун зэвсэг судлалын ангид, 1990-1992 онд Монгол-Японы хамтарсан “Гурван гол” экспедицид оролцон ажиллаж, 1991 онд ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн “Дорнод Монголын экспедиц”, 1992-1994 онд Түүхийн хүрээлэнгийн “Сэлэнгийн экспедиц”, 1994-1995 онд Монгол-Францийн хамтарсан археологийн “Эгийн гол” экспедиц, 1996 онд Монгол-Америкийн хамтарсан “Умард Монгол” археологийн экспедиц, 2003-2004 онд Монгол-Америкийн хамтарсан “Алтайн хадны зураг” экспедиц, 2005 онд Монгол-Америкийн хамтарсан “Тамирын Улаан хошууны Хүннүгийн дурсгал судлах” экспедиц, 2019-2020 онд Монгол-Хятадын хамтарсан “Түйн гол” экспедицийг тус тус Монголын талаас удирдан ажилласан юм. Тэрбээр өөрийн судалгааны үр дүнгээс нэгэн сэдэвт зохиол, хамтын бүтээл 7, эрдэм шинжилгээний өгүүлэл 90 гаруй, эрдэм шинжилгээний хурлын илтгэл 10 гаруйг бичиж монгол, орос, англи, франц хэлээр дотоод, гадаадын мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн байна. 2022 онд МУИС-ийн Монгол судлалын хүрээлэнгээс эрхлэн “МУИС-ийн профессорын эрдмийн өв” цувралаар З. Батсайханы бүтээл туурвилаас 2 ботиор



эмхэтгэн хэвлүүлжээ.

Археологич З.Батсайхан 1990 оноос Хүннүгийн археологийн судалгааны чиглэлээр дагнан ажилласан үр дүнгээ нэгтгэн онолын дүн шинжилгээ хийж 2000 онд “Умард Хүннү ба нүүдлийн иргэншлийн хөгжил” сэдвээр түүхийн ухааны докторын зэрэг хамгаалсан бөгөөд хожим уг бүтээлээ өргөтгөн “Хүннү (Түүх, археологи, угсаатны зүй)” хэмээх ном болгон 2002 онд Улаанбаатар хотноо нийтлүүлжээ. Энэ ном 2006 онд Унгар улсын Будапешт хотноо мажар хэлээр орчуулагдан хэвлэгдсэн нь Ц.Доржсүрэнгийн “Умард Хүннү” зохиолын дараа Монголын археологичдын бүтээлээс гадаад хэлнээ орчуулагдан гарсан хоёр дахь нэгэн сэдэвт бүтээл болсон билээ.

Доктор З. Батсайхан Монгол орон коммунист тогтолцоогоо халж, ардчилал, зах зээлийн харилцаанд шилжих 1990-ээд оны хүнд үед археологийн судалгааг тодорхой зорилго чиглэлтэй, онол арга зүйн зохих түвшинд тасалдуулалгүй явуулах, шинжлэх ухаан технологийн өндөр хөгжилтэй өрнөдийн улс орны эрдэмтэн судлаачидтай хамтын ажиллагаа тогтоож судалгааны шинэ шинэ арга барилыг эзэмших, үндэсний археологийн шинэ залуу боловсон хүчнийг бэлтгэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн судлаач юм.

Тухайлбал, 1991 онд Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голд усан цахилгаан станц барих шийдвэр гарсантай холбогду усан сан тогтоох талбай, түүний ойр орчим дахь археологийн дурсгалуудыг сурвалжлах, хүрээ хэмжээг тогтоох анхны хайгуул судалгааг гүйцэтгэж олон нийтэд мэдээлсэн. Улмаар Эгийн голын сав нутаг дахь археологийн дурсгалуудыг авран хамгаалах малтлага судалгаа гүйцэтгэх үндэсний хээрийн шинжилгээний ангийг 1992-1994 онд удирдан зохион байгуулсан. Энэхүү ажлын үр дүн Монголын төдийгүй гадаадын судлаачдын анхаарлыг татаж 1994 оноос эхлэн ЮНЕСКО-гийн ивээл дор Франц улсын эрдэмтэн, доктор П.-Х.Жискарын тэргүүлдэг Цөлийн хүрээлэн, хожим Йелийн Их Сургуулийн профессор болсон АНУ-ын судлаач У.Ханичёрч нарын удирдсан олон улсын төслүүд тус бүс нутгийн судалгаанд татагдан орж цаашид Монголын археологичидтой олон арван жил тогтвортой хамтран ажиллах үр ашигтай хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан байна.

Доктор З. Батсайхан нь Хүннүгийн археологийн дурсгалыг дагнан судалж, оршуулга тахилгын зан үйл, эд өлгийн судалгаа, ваар савны үйлдвэрлэл зэрэг чиглэлээр нарийн мэргэшсэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй судлаач бөгөөд Сүхбаатар аймгийн Түвшинширээ сумын нутаг Дэлгэрхаан уул, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Бурхан толгой, Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Дуулга уул, Архангай аймгийн Өгийнуур сумын Тамирын Улаан хошуу, Батцэнгэл сумын Эмээл толгой, Булган аймгийн Могод сумын Баруун Мухдаг, Сэлэнгэ аймгийн Сант сумын Өгөөмөр, Баянхонгор аймгийн Өлзийт сумын Соёо хүрэн зэрэг газар хүннү булш малтан шинжилж судалгааны үр дүнг нийтлүүлсэн юм. Түүний явуулсан судалгааны явцад Монголын өвөг ба эртний түүхийн археологийн дурсгалуудыг орчин үеийн археологийн арга зүйгээр малтах, малтлагаас илэрсэн олдворуудын он цаг, хийц бүтэц, технологийг байгалийн шинжлэлийн нарийн аргуудаар шинжлэн судалж, Монголын эртний нүүдэлчдийн угсаа гарлын залгамж холбоо, тэдний өвөг дээдсийн түүх, угсаа гарвалын зангилаа асуудлыг цогцолбороор нэгтгэн дүгнэх боломжийг бүрдүүлсэн байна.

Археологич З. Батсайхан Өмнөговь аймгийн Номгон сумын Баянбулагийн турь, Архангай аймгийн Өгийнуур сумын Талын гурван хэрэм зэрэг Хүннүгийн хот суурины дурсгалыг шинжлэн судлахад чухал үүрэг гүйцэтгэжээ. Тухайлбал, Баянбулагийн туриас гарч буй олдвор хэрэглэгдэхүүнээс энэ хэрэм нь түүхэнд нэр гардаг Хятадын Хан улсаас Хүннүд дагаар орж их говийн умардад бэхлэн суусан Жао Синь жанжинд зориулан байгуулсан хотын үлдэгдэл гэж үзсэн байдаг. З.Батсайханы 2002 онд хэвлүүлсэн “Хүннү” бүтээл нь Хүннүгийн жирийн иргэдийн

булш ба хот суурины хэрэглэгдэхүүнд тулгуурлан Хүннүгийн соёл иргэншлийн өвөрмөц шинж чанарыг тодруулан гаргасан дорвитой бүтээл болсон гэж судлаачид зүй ёсоор үнэлдэг.

Профессор З. Батсайхан шинжлэх ухааны судалгааныхаа ажлыг Хүннүгийн түүх, археологиор голлон явуулахын зэрэгцээ Монголын хүрэл, түрүү төмөр, дундад зууны археологийн судалгааны сэдвээр өргөн цар хүрээтэй ажиллаж олон арван бүтээл туурвисан эрдэмтэн юм. Тухайлбал, Монгол нутаг дахь хүрэл, түрүү төмрийн үе болон эртний улсуудын археологийн соёлуудын залгамж холбооны тухай асуудлыг хөндсөн судалгааны өгүүлүүд бичиж хэвлүүлсэн. 2014-2016 онд Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Монголын эртний нүүдэлчдийн угсаа гарвалын залгамж холбоо (археологи, молекул-генетикийн судалгаа)” сэдэвт ажлын хүрээнд МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхимийн явуулсан малтлага судалгаагаар илрүүлэн олсон эртний 14 хүний яснаас ДНХ ялгах цахиурт холбогч баганын аргаар дээж тус бүрийн агууламжийг спектрофотометр ашиглан тодорхойлсон. Молекул-генетикийн судалгааны үр дүнд хүний ясны дээжээс DNA ялгах арга зүйг тогтворжуулж, энэ төрлийн судалгааг цаашид Монголдоо хийх боломжтой болохыг анх удаа туршилтаар нотолсон юм.

Доктор З. Батсайхан нь МУИС-ийн оюутны дадлагын хүрээнд Архангай аймгийн Хашаат сумын нутаг Шивээ толгой гэдэг газар уулын оройд орших асар том чулуун байгууламжийг 2008 онд малтан судалж Монголд өмнө нь судалж байгаагүй шинэ хэв шинжийн дурсгалыг нээж олжээ. Гадаад хэсэг нь 70 м голчтой, дотоод хэсэг нь тэг дөрвөлжин 36 x 36 м хэмжээтэй, хуудсан чулууг нягт нямбай өрж хийсэн 2 давхар ханатай 100-180 см өндөр байгууламжийг малтах явцад чулуун дараасын дороос толгой, цээж нь хугарч салсан, сайн хадгалагдсан завилан суусан хүн чулуу гарчээ. Энэхүү дурсгал нь Хөшөө Цайдам дахь Билгэ хаан, Куль-тегин нарын тахилын онгоноос өмнө зүг 3 км ойрхон орших бөгөөд магадгүй тэднийг оршуулсан бунхант булш байх боломжтой гэсэн сонирхолтой дүгнэлт хийсэн байна.

Тал нутгийн нүүдэлчид Түрэгийн үеэс эхлэн ийнхүү хаад язгууртнаа уулын оройд тэнгэрт ойр оршуулах болсон нь түүний дараа дараагийн нүүдэлчдийн оршуулгын зан үйлд уламжлагджээ. Тухайлбал, Чингис хаан тэргүүтэй Монголын их хаадыг оршуулсан Бурхан Халдун уулын Ихсийн газрын нэг чухал хэсэг нь Их Хэнтийн нурууны Тэнгэрийн овоо байж болох юм гэсэн саналыг тэрбээр 2006-2009 онд “Тэнгэр угсаа” нийгэмлэгийн хэсэг нөхдийн хамт дэвшүүлэн гаргасан юм. Өмнөх эрдэмтдийн судалгаагаар Чингис хааны булш яг хаана

байгааг тогтоож чадаагүй боловч Их Хэнтийг Бурхан Халдун буюу Ихсийн газар, Их хориг мөн гэдгийг эргэлзээгүйгээр тодорхойлжээ. Судлаачдын олонх нь Бурхан Халдун уулнаа Их хааныг оршуулсан гэдгийг хүлээн зөвшөөрдөг боловч олон жилийн турш тодорхой оноож чадаагүй байсан. Гэтэл З.Батсайхан тэргүүтэй эрдэмтдийн үргэлжлүүлэн явуулсан судалгаагаар Тэнгэрийн овоо нь эртний булш мөн, тэгэхдээ энэхүү асар том байгууламж нь зөвхөн Чингис хааны булш байх боломжтой гэж нотолсон нь тухайн үедээ ихээхэн дуулиан тарьсан билээ. Тэдний судалгаа үндэстэй болохыг олон эрдэмтэн хүлээн зөвшөөрснөөр Монгол Улсын “Соёлын өвийг хамгаалах тухай” хуулинд “Их эзэн Чингис хаан, Монголын хаад, хатдын булш, бунхан, дурсгалын орчин болон олдворыг судлах, хамгаалах, мэдээлэх ажлыг хэрэгжүүлэх талаар холбогдох этгээдэд чиглэл өгөх” бүрэн эрхийг зөвхөн Монгол Улсын Ерөнхийлөгч хэрэгжүүлэхээр хуульчлан зааж өгсөн байна. Улмаар төрийн тахилгат Бурхан Халдун хайрханыг 2015 онд ХБНГУ-ын Бонн хотноо хуралдсан ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн хорооны 39-р чуулганаас “Бурхан Халдун уул, түүнийг хүрээлсэн тахилгат газар нутаг” хэмээх нэрээр Дэлхийн соёлын өвийн жагсаалтанд бүртгэн авчээ.

Профессор З. Батсайхан нь 1997 оноос МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхимд “Археологийн үндэс”, “Археологийн судалгааны арга зүй”, “Монголын археологи”, “Азийн археологи”,

“Археологийн сонгодог сэдвүүд” зэрэг мэргэжлийн үндсэн хичээлүүд, мөн түүх болон угсаатны зүйн тэнхимүүдэд “Археологийн үндэс” хичээл зааж, олон жил тэнхимийн оюутны хээрийн дадлагыг удирдан, археологийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх үйлсэд өөрийн үнэтэй хувь нэмрээ оруулсан багш юм. Энэ хугацаанд бакалавр, магистр, докторын судалгааны ажлыг удирдан хамгаалуулж, 2009 онд МУИС-ийн дэд профессор цол хүртжээ. Тэрбээр МУИС-ийн Археологийн лаборатори байгуулахад чухал үүрэг гүйцэтгэсэн билээ. Монгол оронд археологийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, энэ чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх үйлсэд жинтэй хувь нэмэр оруулсан археологич, доктор, профессор З.Батсайхан багшийн хөдөлмөр бүтээлийг төр засгаас үнэлж 2013 онд “Боловсролын тэргүүний ажилтан” цол, 2021 онд Төрийн дээд “Алтан гадас” одонгоор шагнажээ.

Эрдэм номын хишгээ бид бүхэндээ харамгүй хайрлаж өмөг түшиг болсоор ирсэн Эрхэм багшдаа 70 насны ойг тохиолдуулан урт наслаж удаан жаргахын өлзийтэй ерөөл өргөн дэвшүүлье!

У. Эрдэнэбат, Ц. Төрбат, Ч. Амартүвшин

Улаанбаатар, 2024.05.08